



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/137

Номгон


Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 19 дүгээр зүйлийн 19.2 заалт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2022 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг мөрдүүлэхэд удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т даалгасугай

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2022 оны дугаар
сарын ...-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт

Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох
байгууллагын нэр, чиглэл, хугацаа

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	“АЭАО” ХХК-ний “Энх тунх” клиник эмнэлэг /Улсын бүртгэлийн регистрийн дугаар: /6798721/	Дүрс оношилгоо	3 жил
2	“Мандал гоо фарм” ХХК Шинэжинст сумын Залаа багт /Улсын бүртгэлийн регистрийн дугаар: /3132277/	Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан	3 жил

_____ оОо _____